



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас: 70-32-20-73

2015-06-22 № 3/294
танай _____-ны № _____-т

Зөвлөмжийн хариу


Аймгийн ЗДТГазрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн. Менежментийн захидал, зөвлөмжийн хариуг хүргүүлж байна.

1. ЗДТГазрын ажилтнуудад 2014 онд 30842,0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгож татвар тооцохдоо НДШимтгэл тооцсон дүнгээс ХХОАТ авч 298,1 мянган төгрөгийн татвар дутууг танай байгууллагын 2015 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 41/41 дугаар актын хариуд 2015 оны 6 дугаар сарын 22 –ны өдөр ажилчдын цалингаас суутган тооцоо хийж хүү торгуулийн орлогын 100000952 тоот дансанд шилжүүлсэн болно.

2. Тусгай зориулалтын материал 51,6 мянган төгрөг, бичиг хэргийн материал 973,0 мянган төгрөг, Сэлбэг хэрэгсэл 7981,0 мянган төгрөг, нийт 9005,6 мянган төгрөгийн материалыг шаардах хуудасаар зарцуулагдаагүй шууд зарлагдсан гэж танай байгууллагын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 110/110 дугаар албан шаардлагын хариуд дээрхи дансанд дурдагдсан 9005,6 мянган төгрөгийн бараа материалын шаардах хуудас бүрийг бүрдүүлж холбогдох баримтанд бүртгэсэн байна.

3. ЗДТГазрын даргын 2014 оны 12 дугаар сарын 24-ны а/111 тоот тушаалаар цалингийн зарцуулагдаагүй үлдэгдлээс албан хаагч, ажилчдад 2014 оны үр дүнгийн урамшуулалд 22100,0 мянган төгрөгийг зарцуулсан гэсэн танай байгууллагын 205 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 113/113 дугаар албан шаардлагын хариуд цаашид анхаарч ажиллах болно.

4. Цаашид дээрх зөвлөмжүүдийн дагуу төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, ХХОАТ-ын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтуудыг мөрдөн ажиллаж гарсан зарчил дутагдал давтагдахгүй байх талаар анхаарч ажиллах болно.



Ц.ГАНБОЛД